*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

## ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.АНХБАЯРЫН 2024 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар.

Нэгжийн нэр: Газрын мониторингийн хэлтэс.

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Газрын мониторингийн сүлжээний мониторингийн хот суурины газрын 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийх | [illegible] | [illegible] | [illegible] | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагддаг газрыг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр холбогдох хууль, журамд тодорхой заасан заалт болон нийтлэг зөвлөмж, арга хэмжээний загварыг жагсаалтаар бэлтгэж, системээс автоматаар сонгогдох боломжийг бүрдүүлэх | 60 | [illegible] | [illegible] | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Газрын мониторингийн чиглэлээр хэрэгжүүлэх хэтийн стратегийг боловсруулж, 2024-2029 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулах, | 40 | [illegible] | [illegible] | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтын хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлох | | | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Улсын тусгай хэрэгцээ, ойн сан бүхий, усны сан бүхий газрын мониторингийн цэгийн байршил, байнгын ажиглалтын талбаруудын төлөөлөх талбайн хэмжээ, байршлыг нарийвчлан зураглах талаар санал боловсруулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. "Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих"** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Ойн сан бүхий болон усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран зураглах, газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн сантай холбох | 50 | 5 | 55 | |
| 2. | Арга хэмжээ 2.2.<br>Улсын хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөт хянан баталгааны ажил болон захиалгат хянан баталгааны ажлын үр дүн, мэдээллийг нэгтгэж, газрын мониторингийн цахим системд нөхөж оруулах | 50 | 10 | 60 | |
| **Зорилт 3. "Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх"** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.<br>Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | 54 | 5 | 59 | |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, салбар хоорондын мэдээллийг холбох ажлыг зохион байгуулах | 50 | 10 | 60 | |
| **Зорилт 4. "Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх"** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1.<br>Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | албанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | | | | |
| 2. | Арга хэмжээ 4.2. Архангай аймгийн Өгийнуур, Цэнхэр, Завхан аймгийн Алдархаан, Тосонцэнгэл сумын газар олголт, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | — | — | — | |
| 3. | Арга хэмжээ 4.3. Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 5. “Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1. “Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачилсан заавар”-ыг боловсруулах | 50 | 4 | 54 | |
| 2. | Арга хэмжээ 5.2. “Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэт шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийж, Монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлал”-ыг боловсруулах ажлыг зохион байгуулах | 54 | 0 | 54 | |
| 3. | Арга хэмжээ 5.3 Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 6. “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 6.1. Азийн бэлчээрийн төлөв байдлын мониторингийн зайнаас тандан судлах аргыг боловсруулах төслийн хүрээнд Франц улсаас хэрэгжүүлж буй “FASEP MONGOLIA” төсөлтэй хамтран Баянхонгор аймгийн 7 | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | суманд турших ажлыг зохион байгуулах | | | | |
| 2. | Арга хэмжээ 6.2. Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх гарын авлага боловсруулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 7. “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 7.1. Магадлан итгэмжлэгдсэн хөрсний хяналт, шинжилгээний лабораторит хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд автоматаар оруулах ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 8. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 8.1 Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | 54 | 5 | 59 | |
| 2. | Арга хэмжээ 8.2 Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | 54 | 5 | 59 | |
| 3. | Арга хэмжээ 8.3 Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 8.4 Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | 54 | 5 | 59 | |
| 5 | Арга хэмжээ 8.5 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1 | ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдааныг зохион байгуулах, шүүгчээр оролцох | 60 | 10 | 70 | |
| 2 | Усны өдөрт зориулсан оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг ШУТИС-ын Барилга, архитектурын сургуультай хамтран зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 3 | Мэргэжлийн байгууллагуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 4 | Газрын доройтлыг тодорхойлох, нөхөн сэргээх журмын төслийг сайжруулах | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эрдэмтэн судлаачдын уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулах | | | | |
| 5 | 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний санал бэлтгэх; | 60 | 10 | 70 | |
| | Дундаж оноо: | | | 62.6 | |

1. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | 80% | 12 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Эрх зүйн чиглэлээр баклаврын сургалтад элсэж орох | 100 | 15 | |
| **Дундаж оноо** | | | 13.5 | |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо** | | 7 | |

4. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | [illegible] |
| 2. | Багаар ажиллах | [illegible] |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 7 |

5. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 62.6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 13.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* 91.1 |

| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | 91,1 |
|---|---|

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ............................ Б.ДӨЛ

2024.12.04 (огноо)

● ***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ............................ Г.АНХБАЯР

2024.12.04 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

● ТЗУГ-ын дарга ............................ /............................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.18 (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн ............................ /............................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.18 (огноо)

● ***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ............................ А.ЭНХМАНЛАЙ

2024.12.20 (огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ГАНБАТ ОВОГТОЙ АНХБАЯРЫН 2024 ОНЫ 4 УЛИРАЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх”** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1<br>Газрын мониторингийн сүлжээний мониторингийн хот суурины газрын 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийх | Газрын мониторингийн цахим системд хот суурины газрын 300 мониторингийн цэгт хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлан, дүгнэлт | Газрын мониторингийн үндэсний сүлжээний нийт 2250 мониторингийн цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэсэн. | **Хагас жил:**<br>Газрын мониторингийн сүлжээний мониторингийн 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын даалгаварт санал өгч, батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, ажлын | “Газрын мониторингийн сүлжээний мониторингийн хот суурины газрын 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажыг хийх” ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт санал өгсөн. Гүйцэтгэгчийг сонгох шалгаруулахад шаардлагатай Тендерийн баримт бичигт санал өгсөн.<br><br>Тендерийн үнэлгээний хороог 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж, ирүүлсэн материалыг хянан үзэж үнэлэх ажлыг зохион байгуулахад | 2-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох эхний үе шатанд хяналт тавьж ажилласан байна.<br><br>**Сүүлийн хагас жил:**<br>Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулж, ажлын холбогдох хээрийн болон материал боловсруулалтын үе шатанд хяналт тавьж ажилласан байна.<br>Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтол, элэгдэл, эвдрэлийг тодорхойлж эх үүсвэр, нөлөөллийг тогтоож, газар хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх | дэмжлэг үзүүлэн ажиллаж, Тендерт шалгараагүй оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдлийг боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн дугаар 1/599, 1/600, 1/601, 1/602 албан бичгээр, гүйцэтгэгчээр шалгарсан байгууллагад эрх олгосон тухай мэдэгдлийг боловсрлуулж тус өдрийн дугаар 1/598 албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br><br>2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн дугаар 202410 албан бичгээр үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг баталгаажуулж ирүүлсэн бөгөөд холбогдох нэгжүүдээс санал авч 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дугаар 2024/70 гэрээг байгуулсан.<br>Үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан Ланрес ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 27-ны ажил гүйцэтгэх талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээс бэлтгэл үе шатны тайланг 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 202419 дугаар албан бичгээр ирүүлсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | арга хэмжээг төлөвлөж, үр дүнг газрын мониторингийн цахим системд бүрэн оруулсан байна. | захиалагчийн хяналт хийж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх мониторингийн цэгийн байршилд санал өгч, холбогдох засвар сайжруулалтыг гүйцэтгэгчээр хийлгүүлж байна. Газрын мониторингийн сүлжээний мониторингийн 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын хүрээнд захиалагчийн хяналт хийх ажлын удирдамж 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/267 дугаар тушаалаар батлагдаж хээрийн судалгааны ажлыг Төв аймгийн Борнуур, Баянчандмань сумын мониторингийн 7 цэгт 2024 оны 09 дүгээр сарын 19-нөөс 2024 оны 09 дүгээр сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд 4 цэгээс дээж авч хөрсний дээжийг лабораторит шинжлүүлэхээр өгсөн байна.<br>Мөн гүйцэтгэгч компани 2024.09.20-ны өдөр Гэрээт ажлын хээрийн судалгааны үе шатны тайланг ирүүлсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бөгөөд тайланг хүлээн авч шалган акт, дүгнэлт гаргасан.<br>“Ланрес” ХХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 202425 дугаар албан бичгээр эцсийн шатны тайланг ирүүлсэн бөгөөд тайланг шалгаж үзэн ажлын даалгавар болон гэрээнд туссан ажлаас гүйцэтгэл дутуу ажилбаруудыг тодорхойлж сайжруулах тухай санал гарган 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2/3100 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчээс 2024.12.04-ний өдрийн 202432 дугаар албан бичгээр эцсийн шатны тайлангийн дутуу ажилбаруудыг гүйцээж ирүүлсэнд захиалагчийн хяналт хийж, эцсийн шатны ажил гүйцэтгэсэн акт, дүгнэлтийг гаргаж, САХ-т хүлээлгэн өгсөн. | | |
| 2 | Арга хэмжээ 1.2<br>Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагддаг газрыг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр холбогдох хууль, журамд тодорхой заасан заалт болон нийтлэг зөвлөмж, | Дүгнэлтийн загварт орох багц зөвлөмж, арга хэмжээний жагсаалт | - | **Хагас жил:**<br>Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны дүгнэлтэд тусгагдсан агрохими, хүнд металл, хөрсний эрүүл ахуйн дүн | Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны дүгнэлтийн зөвлөмжийг нэгжийн албан хаагчидтай хамтран дараах агуулгаар загварыг боловсруулсан. Үүнд:<br>1.Газартай холбоотой хууль, эрх зүйн талаарх зөвлөмж,<br>2.Хөрсөн бүрхэвч, үржил шимийг сайжруулах зөвлөмж | 3-6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний загварыг жагсаалтаар бэлтгэж, системээс автоматаар сонгогдох боломжийг бүрдүүлэх | | | шинжилгээ болон санал, зөвлөмжид мэдээллийг автоматаар татагдах загварыг боловсруулж Газрын мониторингийн цахим системд оруулж сайжруулсан байна. | 3.Ургамлан нөмрөг сэргээх, ногоон байгууламж чиглэлээр өгөх зөвлөмж<br>4.Газар ашиглалтын талаарх өгөх зөвлөмж зэрэг 4 үндсэн багц чиглэлийн хүрээнд жишиг 20 гаруй зөвлөмжийг боловсруулсан. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3<br>Газрын мониторингийн чиглэлээр хэрэгжүүлэх хэтийн стратегийг боловсруулж, 2024-2029 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулах, санхүүжилтын хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлох. | 1 төлөвлөгөөний төсөл | - | **Хагас жил:**<br>Газрын мониторингийн сүлжээг өргөжүүлэх, тогтвортой хэвийн ажиллагааг хангах, жил бүр урсгал зардлаар хийгдэх цэгүүдийн тоо хэмжээ, байршил, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх ажлын үе шатны хуваарь, төсвийн тооцоог боловсруулсан байна. | Газрын мониторингийн сүлжээг өргөжүүлэхэд шаардлагатай мониторингийн цэг, ажиглалтын талбарын тоо хэмжээ, ерөнхий байршлыг тодорхойлсон бөгөөд мониторингийн цэгт хянан баталгаа хийх үе шатны хуваарийг боловсруулсан.<br><br>Хот, тосгон, бусад суурины газар болон бэлчээр, тариалангийн газрын төлөвлөгөөт хянан баталгаа хийх төсвийн тооцоог сумдын нутаг дэвсгэрээр боловсруулж, 21 аймгийн 330 суманд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулах талаар21 аймгийн Засаг дарга нарт | 3-6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2024.11.21-ний өдрийн 1/3183-1/3204 дугаартай албан бичгээр зөвлөмж, чиглэл болгон хүргүүлсэн. | | |
| 4 | Арга хэмжээ 1.4<br>Улсын тусгай хэрэгцээ, ойн сан бүхий, усны сан бүхий газрын мониторингийн цэгийн байршил, байнгын ажиглалтын талбаруудын төлөөлөх талбайн хэмжээ, байршлыг нарийвчлан зураглах талаар санал боловсруулах | 1 баримт бичгийн төсөл | | **Хагас жил:**<br>Монгол Улсын байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, газрын нэгдмэл сангийн Улсын тусгай хэрэгцээ, усны сан бүхий газрын байнгын ажиглалтын талбар, мониторингийн цэгүүдэд дүн шинжилгээ хийсэн байна.<br>**Сүүлийн хагас жил:**<br>Улсын тусгай хэрэгцээ, усны сан бүхий газрын мониторингийн цэг болон байнгын ажиглалтын талбарын төлөөлөх талбайн хэмжээг зураглаж, нарийвчлах | Улсын тусгай хамгаалалттай газарт Газар ашиглалт, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор газрын мониторинг хийхэд шаардлагатай байгаа 82-оос доошгүй мониторингийн цэг болон 6314 га ажиглалтын талбар бүхий газрын байршлыг судалж тогтоосон.<br>Усны сан бүхий газарт газар ашиглалт, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор газрын мониторинг хийхэд шаардлагатай байгаа 62-оос доошгүй мониторингийн цэг болон 4464 га ажиглалтын талбар бүхий газрын байршлыг судалж тогтоосон. Улсын тусгай хамгаалалттай газар болон Усны сан бүхий газарт шинээр байгуулах шаардлагатай байгаа мониторингийн 144 цэг болон 7200 га ажиглалтын талбайг судалж тогтоосон. | 5-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | талаар санал боловсруулж, зардлын хэмжээг гаргасан байна. | Мониторингийн цэгүүдийг шинээр байгуулах зардлын тооцоог боловсруулсан. | | |
| **Зорилт 2. “Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих”** | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ 2.1<br>Ойн сан бүхий болон усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран зураглах, газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн сантай холбох. | Ой сан болон усны сангийн батлагдсан хамгаалалтын бүсийг цахим системд оруулсан байна. | - | **Хагас жил:**<br>Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зураглах, газрын мониторингийн цахим системд оруулах ажлыг төлөвлөж, Усны газартай хамтран зохион байгуулсан байна.<br>**Сүүлийн хагас жил:**<br>Газрын мониторингийн цахим системд усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг оруулсан байна. | БОАЖЯ-ны мэдээллийн сантай танилцах мэдээлэл солилцох боломжийг судлах уулзалтыг БОАЖЯам, ЦУОШГазар, Усны газрын холбогдох төлөөлөлтэй 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.<br>Усны газраас Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн мэдээллийг шинэчлэн 2024 оны 08 дугаар сард аймаг тус бүрээр авсан. Газрын мониторингийн цахим системд оруулахаар онцгой хамгаалалтын бүсийн 89863 км2 талбай бүхий хил, энгийн хамгаалалтын бүсийн 142820 км2 талбай бүхий хилийг нэгтгэж бэлтгээд байна.<br>2024 оны Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 69 дугаар тогтоолоор батлагдсан Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн зургийн тоон мэдээллийг нягталж, газрын мониторингийн цахим системд оруулахаар Мэдээлэл | 3-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | технологийн хэлтэст хүргүүлсэн.<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт 2024 онд улсын усны нэгдсэн мэдээллийн санг сайжруулах, хөгжүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн мэдээллийг агуулсан шинэ модуль хөгжүүлсэн бөгөөд тус ажлын хүрээнд Газрын мониторингийн цахим системд сервис үйлчилгээгээр холбох ажил хийгдэж байна. | | |
| 6 | Арга хэмжээ 2.2<br>Улсын хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөт хянан баталгааны ажил болон захиалгат хянан баталгааны ажлын үр дүн, мэдээллийг нэгтгэж, газрын мониторингийн цахим системд нөхөж оруулах | Судалгаа гарч, мэдээллийн сан бүрдсэн байна | | **Хагас жил:**<br>2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газруудын тоон мэдээлэл, мөн захиалгат хянан баталгааны мэдээллийг газрын мониторингийн цахим системд оруулахад хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга | 2010-2023 онд хийгдсэн хянан баталгааны ажлын үр дүнд үүссэн тоон мэдээллийн санг хот тосгон, бусад суурины газар болон бэлчээр, тариалангийн ангилал тус бүрээр нэгтгэх мэдээллийн сангийн загварыг хэлтсийн албан хаагчидтай хамтран боловсруулсан.<br><br>Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгуудад 2010-2023 оны хооронд хийгдсэн газрын төлөв байдал чанарын төлөвлөгөөт хянан баталгааны 10 багц ажлын судалгааг авч нэгтгэсэн. | 3-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зүйгээр хангасан байна.<br>**Сүүлийн хагас жил:**<br>Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, орон нутгийн мэргэжилтнүүдтэй хамтран төлөвлөгөөт хянан баталгааны тоон мэдээллийг газрын мониторингийн цахим системд оруулсан байна. | | | |
| **Зорилт 3. "Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх"** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 3.1<br>Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, | Иргүүлсэн тайлангийн тоогоор | 1. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 126 дугаар тушаалын хавсрлатаар | **Бүтэн жил:**<br>Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгийн ГХБХБГ-ын мониторингийн асуудал хариуцсан | Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь аймгийн ГХБХБГ-ын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, 6-9 сарын хиймэл дагуулын мэдээнд үндэслэж, боловсруулалт хийх ажилд мэргэжил арга зүйгээр хангасан. Мөн аймгуудын | 9-12 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | | "Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар" батлагдсан.<br>2. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 172 дугаар тушаалын хавсрлатаар "Зайнаас тандан судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачилсан заавар" батлагдсан. | мэргэжилтнүүди йг хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн газрын биомассыг тооцох, бэлчээрийн даацыг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна. | боловсруулалт хийсэн 8 сарын мэдээг бэлчээрийн фотомониторингийн үр дүнтэй харьцуулж дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлж ажилласан. | | |
| 8 | Арга хэмжээ 3.2<br>Газрын мониторингийн цахим системийн мэдээлийн сангийн | 4 байгууллагын мэдээлэл (ҮСХ, | | **Хагас жил:**<br>Салбар дундын мэдээллийн санг холбох талаар | Үндэсний статистикийн хороотой малчин өрхийн мэдээллийг байршлаар авах, газрын мониторингийн цахим | 3-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, салбар хоорондын мэдээллийг холбох ажлыг зохион байгуулах. | АМГТГ, ХХААХҮЯ, БОАЖЯ) | | уулзалт зохион байгуулах, мэдээллийг авах ажлыг зохион байгуулсан байна.<br><br>**Сүүлийн хагас жил:**<br>Газрын мониторингийн цахим системд холбогдох мэдээллийг холбосон байна. | системд холбох тухай уулзалтыг 2024 оны 03 дугаар сарын 1, 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд Үндэсний статистикийн хорооны холбогдох албан хаагчидтай зохион байгуулсан.<br>Үндэсний статистикийн хорооны Мал аж ахуйн салбар хариуцсан статистикч Б.Алтансувдаас 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр цахим шуудангаар малчин өрхийн байршил бүхий мэдээллийг хүлээн авсан. Тус мэдээлэлд 65,238 малчин өрхийн координаттай 23,124,520 малын мэдээллийг ирүүлсэн. Тус мэдээлэл нь шаардлага хангаагүй тул мэдээний чанарыг сайжруулж дахин ирүүлж, хамтран ажиллах тухай албан бичгийг Үндэсний статистикийн хороонд 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/2900 дугаартайгаар хүргүүлсэн. | | |
| **Зорилт 4. "Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх"** | | | | | | | |
| 9 | Арга хэмжээ 4.1<br>Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Холбогдох албан хаагчид | МУ-ын ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Газрын төлөв байдал чанарын хянан | **Хагас жил:**<br>Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан | Салбарын хяналтын хэлтсийн боловсруулсан төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжид мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хяналт-шинжилгээ хийх санал боловсруулж өгсөн. | 3-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баталгаа хийх журмыг шинэчлэн боловсруулж, тус арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг тусгасан | нэгжтэй хамтран хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ. Үнэлгээний үр дүнд үндэслэн Суурь судалгаа мониторингийн асуудал хариуцсан албан хаагчдын үйл ажиллагааг сайжруулах сургалт зохион байгуулах. | Мөн Мониторингийн асуудал хариуцсан албан хаагчдын үйл ажиллагааг сайжруулахаар сургалтын хөтөлбөр боловсруулж 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр газрын даргаар батлуулан. 2024 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 21 аймгийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд НГЗБА-ы ГМХ-ийн мэргэжилтнүүд дүүргийн ГЗБА-ы ахлах мэргэжилтнүүд зэрэг 40 гаруй албан хаагч оролцсон.<br>Мөн тус ажлын хүрээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн 35-00/04 дугаартай удирдамж батлуулж Нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн. Нийслэл, дүүргийн хэмжээнд эрх бүхий этгээдийн шийдвэр гарч иргэн, хуулийн этгээдэд олгосон 501510 нэгж талбарын мэдээллийг нарийвчлан шалгаж газар олголтын байдал, дуудлага худалдаа, төлбөрийн мэдээлэл, талбайн хэмжээ болон зориулалтын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу ашиглаж байгаа эсэх хяналтын ажлыг гүйцэтгэж ажлын үр дүнг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр газрын даргад танилцуулсан. | | |
| 10 | Арга хэмжээ 4.2 Архангай аймгийн Өгийнуур, Цэнхэр, Завхан аймгийн Алдархаан, Тосонцэнгэл сумын газар олголт, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | | **Хагас жил:** Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Шалгалтын дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна | Хяналт шалгалтын ажлын хэсэгт орж ажлаагүй тул үнэлэх боломжгүй. | 2-6 | |
| 11 | Арга хэмжээ 4.3 Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо | | **Хагас жил:** Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийсэн байна. **Сүүлийн хагас жил:** Хяналт шалгалтын дүнг холбогдох хурлаар | Салбарын хяналтын хэлтсийн боловсруулсан төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжид мэргэжлийн байгууллагуудыг шалгах загварыг боловсруулж санал өгсөн. Хяналт шалгалтын ажлыг Хяналтын хэлтэстэй хамтран хянан баталгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20 аж ахуйн нэгжид зохион байгуулах | 3-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна | тухай тушаалын төслийг боловсруулж, Газрын даргаар 2024 оны 10 дугаар сарын 25 өдрийн А/314 дугаартайгаар батлуулсан. Тус ажлын хүрээнд 5 мэргэжлийн байгууллагын гүйцэтгэсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны 20 тайлангийн чанарын гүйцэтгэлд хяналт хийж санал, зөвлөмж бүхий нэгдсэн тайланг боловсруулсан. | | |
| **Зорилт 5. “Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох”** | | | | | | | |
| 12 | Арга хэмжээ 5.1 “Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачилсан заавар”-ыг боловсруулах | 1 заавар | | **Хагас жил:** Ажлын даалгавар боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах дэмжлэг үзүүлж ажилласан байна. **Сүүлийн хагас жил:** Аргачлалын төслийг хүлээн авч, бусад байгууллагаас санал авч холбогдох | “Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачилсан заавар”-ыг боловсруулах ажил гүйцэтгэх ажлын даалгаварыг боловсруулсан. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дугаар 1/644 албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэгчээс 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дугаар 202412 албан бичгээр гэрээний төслийг баталгаажуулж ирүүлсэн бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 2024/71 дугаартай гэрээг байгуулсан. | 3-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагаас санал авч, газар зохион байгуулалтын орон тооны бус зөвлөл Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, баталсан байна. | Үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан Ланрес ХХК-тай 2024 оны 03 дугаар сарын 27-ны ажил гүйцэтгэх талаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээс бэлтгэл үе шатны тайланг 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 202419 дугаар албан бичгээр ирүүлсэн захиалагчийн хяналт хийж, газрын мониторингийн цэгийг өтгөрүүлэх шаардлага зарчмын хэсэгт холбогдох засвар сайжруулалтыг гүйцэтгэгчээр хийлгүүлж, 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр ажил шалгаж хүлээн авсан №2024/71-01 дугаартай дүгнэлт үйлдэж Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн. Эцсийн шатны тайланг 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 202424 дугаар албан бичгээр ирүүлсэнд захиалагчийн хяналт хийж, холбогдох засвар сайжруулалтыг хийлгүүлэх тухай албан бичгийг 2024 оны 2/3115 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гүйцэтгэгчээс 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 202432 дугаар албан бичгээр ирүүлсэнд захиалагчийн хяналт хийж, САХ-т хүлээлгэн өгсөн.<br><br>2024 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр ХХААХҮЯам, Усны газар, Нийслэлийн байгаль орчны газрын холбогдох мэргэжилтнүүд болон МУИС, ХААИС-ийн эрдэмтэн багш нарыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, "Газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачилсан заавар"-ын төсөлд санал авсан. Зааварын төслийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр аргачлылн төслийг хэлэлцүүлсэн. | | |
| 13 | Арга хэмжээ 5.2 "Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, | 1 аргачлал | | **Хагас жил:** Аргачлалын төслийг холбогдох Газар зохион байгуулалтын | "Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэт шинэлэг технологийн | 3-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэвшилтэт шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийж, Монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлал"-ыг боловсруулах ажлыг зохион байгуулах | | | орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн болон Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.<br><br>**Сүүлийн хагас жил:**<br>Аргачлалын төслийг турших, холбогдох газруудаас санал авч сайжруулан, батлуулсан байна. | аргачлалын судалгаа хийж, Монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлал"-ыг гүйцэтгэх ажлын даалгаварт санал өгсөн.<br><br>Үнэлгээний хороог хуралдуулах тендерийн баримт бичгийг дахин боловсруулж дэмжлэг үзүүлж батлуулан 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Тендерт оролцох урилгыг ГЗБГЗЗГ/20240203011/02/01 дугаартайгаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлж, тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг 2024 оны 03 дугаар сарын 26-ний өдөр хүлээн авч, тендерийг нээсэн.<br>Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 2024/105 дугаартай гэрээг байгуулсан. Бэлтгэл үе шатны тайланд захиалагчийн хяналтыг тавьж шаардлагатай засвар сайжруулалтыг хийлгүүлэхээр гүйцэтгэгчид буцаасан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гэрээт ажлын гүйцэтгэгч нартай ажлын явц, аргачлалын арга зүйн талаар 2024 оны 07 дугаар 30-ны өдөр уулзалт зохион байгуулсан.<br>Тус ажлын тайлан, аргачлалын төслийг ирүүлэх тухай 3/2541 дугаартай албан бичгийг 2024.09.23-ны өдөр явуулсан.<br><br>Аргачлалын төслийн арга зүй, ажлын явцын талаар 2024.09.30-ны өдөр уулзалт зохион байгуулж ажлын явц гүйцэтгэлд шаардлагатай сайжруулалтын саналыг өгсөн.<br>2024.11.21-ний өдөр ХХААХҮЯам, Усны газар, Нийслэлийн байгаль орчны газрын холбогдох мэргэжилтнүүд болон МУИС, ХААИС-ийн эрдэмтэн багш нарыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлалын төсөлд санал авсан.<br>2024.12.05-ны өдөр Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр аргачлалын төслийг хэлэлцүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр ажлын эцсийн шатны тайланг ирүүлсэн захиалагчийн хяналт хийж дүгнэлт үйлдэн САХ-т хүлээлгэн өгсөн. | | |
| 14 | Арга хэмжээ 5.3 Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Мэдээлэл өгч, сурталчилсан ажлын тоо | | **Хагас жил:** Шинэчилэн батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны журам"-ыг танилцуулах, орон нутагт чиглэл хүргүүлэх, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна | Шинэчлэн батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны журам"-ыг танилцуулах, орон нутагт чиглэл хүргүүлэх, мэдээлэл өгөх сургалтыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны газрын ашиглалт мониторингийн хэлтсийн холбогдох албан хаагчид болон дүүргийн газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтнүүдэд 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр танхимаар зохион байгуулсан. Мөн тус сургалтыг 21 аймгийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан.<br>2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр 21 аймаг, нийслэлийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд чадавхижуулах танхимын сургалтын хөтөлбөрийг боловсруулж газрын даргаар батлуулан 2024 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд | 3-12 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан. Тус сургалтад 21 аймгийн мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд НГЗБА-ы ГМХ-ийн мэргэжилтнүүд дүүргийн ГЗБА-ы ахлах мэргэжилтнүүд зэрэг 40 гаруй албан хаагч оролцсон.<br>2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны нийт албан хаагчдад Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны шинчилэн батлагдсан журмыг болон хянан баталгаатай холбоотой анхаарах асуудлуудын талаарх танилцуулгыг хийсэн.<br>2024 оны 11 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Баян-Адрага, Баян-Овоо, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ИТХ-ын дарга, гишүүд болон сумын ЗДТГ-ын дарга нартай уулзалт зохион байгуулж, 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам", "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-уудыг танилцуулж, хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгсөн. | | |
| **Зорилт 6. "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах"** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 6.1<br>Азийн бэлчээрийн төлөв байдлын мониторингийн зайнаас тандан судлах аргыг боловсруулах төслийн хүрээнд Франц улсаас хэрэгжүүлж буй "FASEP MONGOLIA" төсөлтэй хамтран Баянхонгор аймгийн 7 суманд турших ажлыг зохион байгуулах | Хөгжүүлэлт хийсэн портал, түүнийг хэрэглээнд туршсан байдал | ГЗБГЗЗГ, Хил хязгааргүй малын эмч нар ба агрономчид Консорциумтай хамтран ажиллах санамж бичиг | **Хагас жил:**<br>Хээрийн судалгааны аргаар болон хиймэл дагуулын зураглалын үр дүнг хослуулан бэлчээрийн төлөв байдалд бодит цагийн мониторинг хийх арга зүйн техник эдийн засгийн үндэслэлийг судлан, вэб порталд суурилсан шийдлийг боловсруулсан байна.<br>**Сүүлийн хагас жил:**<br>Шийдлийг Баянхонгор аймгийн 7 сумын бэлчээрийн фото мониторингийн үр дүнтэй давхцуулан туршилт хийсэн байна. | Франц улсаас хэрэгжүүлж буй "FASEP MONGOLIA" төслийн багийнхантай 2024 оны 02 дугаар сарын 23, 27-ны өдрүүдэд цахим уулзалтыг зохион байгуулж, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлын талаар ярилцсан.<br><br>Мөн тус төслийн хүрээнд Франц улсын хиймэл дагуулын судалгааны байгууллага /CLS/-ын инженерүүд, Хил хязгааргүй малын эмч нар болон агрономичид олон улсын байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчидийг хүлээн авч, 2024 оны 3 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд ГЗБГЗЗГЕГ-т ажиллахад дэмжлэг үзүүлэн, төслийн хүрээнд хөгжүүлж буй портал сайт болон мониторинг, зайнаас тандан судлалын чиглэлээр онол, практикийн сургалтыг хамтран зохион байгуулж агентлагаас 15 албан хаагчийг сургалтад хамруулж, чадавхжуулсан.<br>Мөн төслийн хаалтын зөвлөлдөх, уулзалт сургалтыг төслийн багийнхантай хамтран 2024 оны 6 дугаар сарын 05-ний өдөр зохион байгуулж агентлагаас 15 албан хаагчийг сургалтад хамруулж, чадавхжуулсан. | 3-12 | |

120

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Арга хэмжээ 6.2<br>Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх гарын авлага боловсруулах. | Гарын авлага - 1 | - | **Хагас жил:**<br>Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх гарын авлагын эхийн төслийг боловсруулсан байна.<br>**Сүүлийн хагас жил:**<br>Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх гарын авлагын эхийг бэлтгэж, цахим хувилбарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. | Газрын мониторингийн мэргэжилтнүүдэд зориулсан “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх” гарын авлагыг Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн доктор Б.Баяртунгалагтай хамтран боловсруулж, “Адмон” ХХК-д 79 хуудастай 400 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, СЭЗХ-т хүлээлгэн өгсөн.<br>Хэвлэлийг эхийг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр нээлттэйгээр байршуулсан. | 3-9 | |
| **Зорилт 7. “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах”** | | | | | | | |
| 17 | Арга хэмжээ 7.1<br>Магадлан итгэмжлэгдсэн хөрсний хяналт, шинжилгээний лабораторит хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд | Лабораторийн шинжилгээний хариуны тоо | Газрын мониторингийн цахим систем ажиллуулах журам батлагдсан. Лабораторийн эрхлэгчид олгох эрхийн | **Хагас жил:**<br>Итгэмжлэгдсэн лабораториудтай уулзалт зохион байгуулж, газрын мониторингийн системд нэмэлт хөгжүүлэлт хийж, үйл ажиллагаанд | Итгэмжлэгдсэн хөрсний хяналт, шинжилгээний лабораторид хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд автоматаар оруулахад шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хэлтсийн албан хаагчидтай | 3-6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | автоматаар оруулах ажлыг зохион байгуулах | | модулийн тохиргоо хийгдсэн. | нэвтрүүлсэн байна. | хамтран Эрхэт инноваци ХХК-иар гүйцэтгүүлж, хийгдсэн хөгжүүлэлтийг шалгаж, холбогдох туршилт хийж цахим системд оруулах ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус хөгжүүлэлт нь 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтэрсэн. | | |
| **Зорилт 8. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх”** | | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 8.1 Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнаж ажиллаж байна | 2-12 | |
| 19 | Арга хэмжээ 8.2 Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Газрын даргын 2024 оны А/130 дугаартай Үндэсний статистикийн хороотой мэдээлэл солилцох, цахим системтэй холбох боломжийг шийдвэрлэх ажлын хэсэгт орж ажиллаж Үндэсний статистикийн хорооноос 65,238 малчин өрхийн координаттай 23,124,520 малын мэдээллийг хүлээн авсан.<br>Газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 25 өдрийн А/314 дугаартай Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан | 2-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх хяналт шалгалт гүйцэтгэх тухай тушаалын ажлын хэсэгт нарийн бичгээр ажиллаж Газрын хянан баталгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 20 мэргэжлийн байгууллагын гүйцэтгэсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны 100 тайланг ГМХ-ийн албан хаагчидтай хамтран ажлын гүйцэтгэл, чанарт хяналт хийж санал, зөвлөмж бүхий нэгдсэн тайланг боловсруулсан. | | |
| 20 | Арга хэмжээ 8.3 Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 тогтоолын арга хэмжээний биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын байдлаар боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/2901 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2-12 | |
| 21 | Арга хэмжээ 8.4 Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 98 албан бичиг, хүсэлтийг цаг тухай бүрт нь шийдвэрлэн, 52 албан бичгийг хүргүүлэн ажилласан. Иргэний 2 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна. | 2-12 | |
| 22 | Арга хэмжээ 8.5 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан "Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх | 2-3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | | | оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэт шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийж, Монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлал"-ын тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж хүлээлгэн өгсөн. | | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдааныг зохион байгуулах, шүүгчээр оролцох | Илтгэлийн уралдааныг зохион байгуулах | | ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдааныг зохион байгуулсан байна. | ЕБС-ийн IX-XII ангийн сурагчдын дунд "Хөрс, ус, агаар орчны судалгаа-Globe 2024" илтгэлийн уралдааны удирдамжийг батлуулж, Боловсролын Ерөнхий газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, нийслэлийн ерөнхий боловсролын "Шинэ эхлэл" сургуультай хамтран 2024 оны 02 сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Тус уралдаанд шүүгчээр ажилласан. | 2 сард | |
| 2 | Усны өдөрт зориулсан оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг ШУТИС-ын Барилга, архитектурын сургуультай хамтран зохион байгуулах | Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах | | Усны өдөрт зориулсан оюутны эрдэм шинжилгээний бага хурал оролцож шүүгчээр ажилласан байна. | ШУТИС-ын Барилга, архитектурын сургуультай хамтран 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Усны өдөрт зориулсан оюутны эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг хамтран зохион байгуулж, шүүгчээр ажилласан. | 3 сард | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Мэргэжлийн байгууллагуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулах | | Мэргэжлийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан байна. | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудад орох сургалтын удирдамжийг боловсруулан газрын даргаар батлуулсан. Сургалтыг 55 мэргэжлийн байгууллагын 60 гаруй ажилтаныг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. | 5 сард | |
| 4 | Газрын доройтлыг тодорхойлох, нөхөн сэргээх журмын төслийг сайжруулах эрдэмтэн судлаачдын уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулах | Хэлэлцүүлэг зохион байгуулах | | Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна | Газрын мониторингийн сүлжээ ажиллуулах, салбар дундын мэдээллийн сан үүсгэх журмын төслийг сайжруулахаар Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Усны газар, Нийслэлийн байгаль орчны газар, Ус цаг уур орчны шинжилгээний газар болон холбогдох байгууллагуудын 20 гаруй ажилтануудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулсан. | 5 сард | |
| 5 | 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний санал бэлтгэх; | Төлөвлөгөөний төсөл | | Төлөвлөгөөний төслийн саналыг боловсруулсан байна. | 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд Газрын мониторингийн хэлтсээс оруулах саналыг бэлтгэж хэлтсийн даргад танилцуулсан. | 11 сард | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | Гэрчилгээ авсан байна. | - | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд | 2024 оны 02 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны | 2-3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдаж гэрчилгээ авсан байна. | газраас цахим систем /tender.gov.mn/-д шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан шалгалт аваагүй тул шалгалтаа өгч чадаагүй байна. | | |
| 2. | Арга хэмжээ 2. Эрх зүйн чиглэлээр баклаврын сургалтад элсэж орох | Их, дээд сургуульд элсэн орсон байна. | | Их дээд сургуульд эрх зүйн чиглэлээр баклаврын сургалтад элсэн орж хаврын улирлын хичээлүүдийг үзсэн байна. | Идэр их сургуульд элсэн орж эрх зүйн чиглэлийн 10 хичээлд долоон хоног бүрийн баасан, бямба гарагт бүтэн хамрагдаж хаварын улиралын хичээлийг амжилттай дүүргэсэн. | 3-12 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

.............................. Г.АНХБАЯР

2024-12-04